

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот:

Удирдлага зохион байгуулалтын талаар:

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлиг, Монгол Улсын Ерөнхий сайдын “Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах тухай” 02 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний 03 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын А/335 захирамж, Улсын Их хурлаас Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Болзолт уралдаан зарлах тухай” А/177, “Зорилт батлах тухай” А/181, “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай” А/196, “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” А/252 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2017 оны “Тооллого явуулах тухай” А/688 дугаар Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/177 дугаар захирамжуудын хэрэгжилтийг хангуулахаар байгууллагын даргын А тушаал 23, Б 26 тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, байгууллага аж ахуйн нэгжээс цахимаар болон албан бичгээр ирсэн нийт 81 албан бичигт хариуг хугацаанд нь хүргүүлж, байгууллагын зүгээс 99 албан бичгийг боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Ахмадын орон сууц хөтөлбөрт хамрагдах иргэдийг сонгон шалгаруулах шинэчилсэн журам” батлах тухай А/671 дүгээр захирамжийн дагуу 2017 онд Ахмадын орон сууцанд амьдарч буй оршин суугчдаас гэрээ дуусгавар болсон 901 дүгээр байрны 56, 123, 77, 145, 150 тоот 902 дугаар байрны 18, 39, 46, 101, 140 дүгээр тоотуудад байраа чөлөөлж өгөх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлж ажилласаны үр дүнд дээрх орон сууцнуудад Нийслэлийн Засаг даргын А/677 захирамжаар 901-р байрны 77 тоотод иргэн Ц.Хандсүрэн, 902-р байрны 18 тоот Д.Бадам, 902-р байрны 39 тоот Г.Дорлиг, 902-р байрны 54 тоот П.Байгалмаа, Нийслэлийн Засаг даргын А/820 захирамжаар 902 дугаар байрны 6 тоотод иргэн Д.Цэнд-Аюуш, 902 дугаар байрны 46 тоот Д.Сүрэнжав, 902 дугаар байрны 53 тоот Г.Зина, 902 дугаар байрны 146 тоот Д.Аюуш, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/208 дугаар захирамжаар 17/001 эрхийн бичгийг Чингэлтэй дүүргийн иргэн Ц.Давааням, 17/002 эрхийн бичгийг Ё.Цог нарын 10 айлтай орон сууц түрээслэх гэрээг шинээр байгуулж, “Ахмадын

орон сууцыг тусгай нөхцөлтэйгөөр хөлслүүлэх гэрээ”-ний сунгалтыг нийт 287 айл өрхтэй байгуулж, Сүхбаатар дүүргийн 11 хороо Гэр хороолол дэд бүтцийн газрын эзэмшлийн Түр суурьшуулах 813 дугаар байрны 156 айл өрхийн судалгаанд шинээр баяжилт хийж иргэд оршин суугчдын ая тухтай орчинд амьдрах нөхцлийг хангуулж ажиллаа.

Сар бүрийн 25-ны дотор тус хотхоны оршин суугчдын хөдөлгөөний судалгааг нийслэлийн Захирагчийн ажлын албаны орон сууц хариуцсан мэргэжилтэн Э.Шийтэрийн [d.shiiter@yahoo.com](mailto:d.shiiter@yahoo.com) цахим хаягаар сар бүр хүргүүлж, айл өрхүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр албан тоотыг тус байгууллагад хүргүүлж одоо орон сууц ашиглалт 100%-тай байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэх захирамжийн төслийг 2017 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаартай албан тоотой хүргүүлж, нийслэлийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/749 захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлуулсан.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-12.2.8 дах заалтад тусгагдсан тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлтийг холбогдох материалын хамт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах Зөвлөлд хүргүүлж 2017-2020 он хүртэл үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хоёр.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт,үр дүн

Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Тооллого явуулах тухай” А/688 дугаар захирамжийн хүрээнд архивын баримтанд нэгдсэн тооллого явуулах ажлын аргачилсан зөвлөмж сэдэвт нэгдсэн сургалтанд 2 ажилтан хамрагдаж, нийслэлийн Архивын газрын Архивын нэгдсэн тооллогыг заасан хугацаанд нь явуулж байгууллагынхаа данс бүртгэлээр түр хадгалах баримт 57, байнга хадгалах баримт 40, Зураг төсөл 16, 70 жил хадгалах 2 баримт нийт 115 хадгаламжийн нэгжийг тооллогод бүртгүүлж, 2016 оны үйл ажиллагааны хүрээнд хөтлөгдсөн 10 ширхэг архивын нэгжийг хүлээн авч, 450000 төгрөгийн төсөв зардал гарган байгууллагын архивын өрөөг шинээр байгуулж архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Нийслэлийн орон сууцны хөтөлбөр батлах тухай” 17/17 дугаар тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.13 “Ахмадын орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд Ахмадын хотхоны 901-р байрны 05, 06 тоот өрөөнд түрээсийн гэрээний дагуу эмийн сан, хүнсний дэлгүүр ажиллуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-ний сунгалтыг нийслэлийн Өмчийн харилцааны газраар хийлгэн эхний 11 сард эмийн сан 3,8 сая төгрөг, дэлгүүр 4,2 сая төгрөг нийт 8 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын дансанд төвлөрүүлж 2017 оны 11 сарын байдлаар 901,902,813 дугаар байрны орон сууцны түрээс ашиглалт үйлчилгээний төлбөр 503,1 сая төгрөгийн орлого татан төвлөрүүлж ажиллаа.

## Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

Хотхоны сантехникч, цахилгаанчин, харуул, лифтчин, үйлчлэгч нарт өдөр тутмын ХАБЭА-н зааварчилгаа өгч ээлжийг хүлээлцүүлэн, үүрэг даалгавар өгч, УДДТөв гадна шугам сүлжээ, халаалт, байруудын халуун хүйтэн ус, ариутгах татуурга зэрэгтэй холбоотой дуудлаганд өдөр бүр хяналт тавьж, инженерийн шугам сүлжээний талаар заавар зөвөлгөө, техник тоног төхөөрөмжтэй зөв харьцах аюулгүй ажиллагааны зааварчлага өгч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

2017 онд түр суурьшуулах 813, 901, 902-р байрны оршин суугчдаас ирсэн ариутгах татуургын 113, цэвэр болон бохир халуун хүйтэн устай холбоотой 452, дулаантай холбоотой 47 дуудлага, эрчим хүчтэй холбоотой 240 дуудлага нийт 852 дуудлагыг тус тус хүлээн авч засвар үйлчилгээг түргэн шуурхай барагдуулж иргэд оршин суугчдын тав тухтай амьдрах орчин нөхцлийг хангаж ажиллаа.

**-Ус дулаан дамжуулах төвүүдэд хийгдсэн засвар үйлчилгээ:**

Түрээсийн 813-р байрны халуун ус 10-14 давхартаа хүрэхгүй даралт унадаг байсан тул тус барилгын гүйцэтгэгч компани болох Баярс констракшн ХХК-д шаардлага тавьж, холигч насосны узельд соронзон пускатель тавиулж, өргөлтийн насосын чадлыг нэмэгдүүлэн хэвийн ажиллагааг хангахад нийт 9 нэр төрлийн 1,9 сая төгрөгийн төсөв зардал гарган засварласан.

(Зураг -1)



Ус дулаан дамжуулах төв /ЦТП-95-2/-ын автомат тохируулгын хаалтыг мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээ хийлгэж, ДШСТӨХК-ний тохируулгын инженер н.Чадраабалаар тохируулга хийлгэж, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 100-ын хаалт-1, 150-ын хаалт-2, 200-ын хаалт -1 ширхэгийг тус тус шинээр худалдан авч нийт 2 сая төгрөгийн засварийн ажил хийгдсэн.

(Зураг-2)



УДДТөвүүдийн холигч насоснуудын техник тоног төхөөрөмжинд үзлэг шалгалт хийж, 901, 902-р байр халуун усны насосуудад аваарын үеийн сэлгэн залгуур, иж бүрдэлийн хамт шинээр угсарч найдвартай ажиллагааг хангуулав.

(Зураг-3)



Тус хотхоныг дулааны эрчим хүчээр хангах төвийн 1 дүгээр шугамаас хэрэглэгч рүү дулаан дамжуулах 2 дугаар хэлхээнд дулааны эрчим хүч дамжуулах шугамын ф/200-ын хаалт-1 ширхэг, ф/150-ын 2 ширхэг хаалтууд техникийн шаардлага хангахгүй болсон тул дээрх хаалтуудыг салгаж шинээр хаалт тавих, хучилтын хавтан нь цөмрөлт өгч шугамаа дарсан байсныг шинээр сольж тавих дулааны шугам хоолой, худагт хуримтлагдсан хог шороог цэвэрлэн гаргаж, засвар үйлчилгээг 2017 оны 08 дугаар сарын 02-05 өдрүүдэд хийж өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан.



(зураг-4) Хучилтын хавтан цөмөрсөнийг шинээр сольж буй байдал



(Зураг-5) узель доторх ф-200-ийн хаалтыг шинээр сольж гагнаж тавьсан байдал



(Зураг-6) УДДТ-ийн дулаалга үйлчилгээ хийгдсэн байдал

**-Байгууллагын цэвэр болон бохир усны худагт хийгдсэн засвар үйлчилгээ:**

Бохир усны 26 худагт үзлэг шалгалтыг сар бүрийн 10, 25-нд тогтмол хийж цэвэрлэн, эхний хагас жилд 9 худгийн тагийг шинээр лист төмрөөр сольж бэхлэн,

5 худагт 2 удаа хог шүүгчийг шинээр сольж, 6 удаа ариутгах татуургын шугам хоолойн бөглөрлийг гаргаж ажилласан.

(Зураг-7)



Цагдаагийн 515-р байрны хажууд байрлах бохирын худгийн тагийг засварлан битүүлж бэхэлгээ хийлгэв.

(Зураг-8)



“Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ын 901, 902 дугаар байр түр оршин суух 813 дугаар байрны халаалтыг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс авч халаалтын хэвийн горимд хангуулахаар газрын даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажил үүрэг гүйцэтгэх тухай” А/13 дугаар тушаал гарган инженер техникийн ажилчдыг хуваарийн дагуу үүрэг гүйцэтгүүлж, орон сууцанд оршин суугч иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахад нийт 1.843,106 төгрөгийг төсөвт ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж 87,2 хувийн биелэлттэй, захирамж, албан даалгаврын биелэлтийг бүрэн хангуулж ажиллаа.

#### **-Цахилгааны хуваарилах самбарт хийгдсэн засвар үйлчилгээ:**

Түр суурьшуулах 813-р байрны граж, 156мкв, 170мкв офиссын зориулалттай заалнуудын 380вт, 220вт-н тоолууртай болгож, халуун хүйтэн усны тоолуур нэмэлтээр тавьж заалтуудыг тэмдэглэн, ашиглалтыг тооцон ажиллаж байна.

Түр суурьшуулах 813-р байрны 4-р давхар 30-35-н тоотын 6 айлын тоолуурын хуваарьлах самбарт 63 амперийн автомат шатсаныг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулав.

#### **-Цахилгаан шатанд хийгдсэн засвар үйлчилгээ:**

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ, Галт урсгал лифт ХХК-уудаар 813, 901, 902-р байрны лифтэнд гэрээний дагуу өргөх, буулгах моторын тосыг солиулж, эсрэг ачааны замуудын тосолгоо, техникийн үйлчилгээг тогтмол хийлгэж цахилгаан шатны хэвийн ажиллагааг бүрэн хангуулсан.

902-р байрны 12 давхар лифтний товч, 4-р лифтний 2 давхарын болон хонгилын хаалганы гүйлтийн дамрыг сольж, 3-р лифтний өргөлтийн тросс уртассан тул

сойлт хийж түр зогсоолгон троссыг солиулах арга хэмжээг авч, Улаанбаатар лифт ОНӨААТҮГээр 901, 902-р байрны лифтэнд техникийн магадлал хийлгэв.

Цахилгаан шатны хонгилын гэрэлтүүлгийн гэрлийн шил 40 ширхэгийг сольж аюулгүй ажиллагааг хангуулсан. Цахилгаан шатны засварт нийт -3,1 сая төгрөг, гэрээний дагуух үйлчилгээнд- нийт 3,8 сая төгрөг нийт 6,9 сая төгрөг зарцуулсан. Улаанбаатар лифт ХХК, Галт урсгал ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 6,4 сая төгрөгийг шилжүүлсэн.

(Зураг-9 )



#### **-Байрны дотор болон гадна орчинд хийгдсэн тохижилт үйлчилгээ:**

Ахмадын хотхоны 901, 902-р байрны 30 гаран айл өрхийн агааржуулалт, салхивч хоолойн зай завсраар салхи үлээн айлуудын банн, гал тогооны халуун хүйтэн усны шугамууд хөлдөөд байсныг салхивчны хоолойн хажуугийн зай завсруудыг хөөсөөр битүүлэн чигжиж дулаалах, 901-р байрны орцны хаалганд вакум хаалт, хаалга хийх, 813-р байрны граашид дутуу байсан 2 регистерийг холбож гараашийн халаалтыг жигдрүүлэв.


Байгууллагын албан контор 813 дугаар байранд шилжин байралсантай холбогдуулан конторын 8 цонхонд хаалт тор гагнаж хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.

Зураг-(10)



Түр суурьшуулах 813-р байрны 38 тоот айлын паркетан шал хууларсаныг засуулан, сар шинийн баярын өдрийг угтаж, 901, 902-р байрнуудын орц, 1-15 давхарын шатны хонгил, айл өрхийн коридорын хэсгийн хана, таазыг сэргээн засварлах ажлыг зохион байгууллаа.

(зураг-11)



Түр суурьшуулах 813 дугаар байр, Ахмадын хотхоны 901, 902-р байрны шатны хонгил лифтний талбай бүх орцны гэрэл чийдэн мэдрэгчүүдийг сольж, 902-р байрны орцны гадна хаалга салхи цохин хүчтэй савж хаагддагаас болж хаалга хөдөлгөөн орсныг засварлан, 901 дүгээр байрны хоёрдугаар давхарт үйлчлэгчийн өрөө шинээр гарган вакуум хаалт хийж, цэвэр бохир усны шугам шинээр татаж тосгуур суурилууллаа.

(зураг-12)



Оршин суугч иргэдийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр “Төгс хурц консалтинг” ХХК-тай 9,8 сая төгрөгийн Худалдах худалдан авах гэрээ байгуулан түр суурьшуулах 813 дугаар байрны орцны явган шат, лифт, гадна үүдний хэсэгт нийт 22 ширхэг камер суурилуулж, 901,902-р байрны 4 ш камерийн хүчин чадлыг сайжруулснаар иргэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангасан.

Түр суурьшуулах 813 дугаар байранд хотхоны захиргаа шилжин байршсантай холбогдуулан Скай медиа ХХК-тай интернэт үйлчилгээ авах гэрээ байгуулж нийт 6 өрөөнд интернэтийн сүлжээг оруулж байгууллагын цахим хэрэглээ хангагдсан.

Хотхоны 901-р байрны 1 тоотоос дээшхи халуун усны босоо шугамын 15-н айлын хэрэглээний халуун усны даралт муу байсан тул халуун усны босоо шугамыг задлан шалгаж, 11, 21 тоотын хооронд 20см орчим урттай 8мм-ын арматур төмрийг гаргаж хэвийн ажиллагааг хангуулж, тус байрны нөөц насосонд 380вольтын хүчдэл бүхий автомат дулааны реллей тавьж, шаардлагатай үед холбох бэлтгэл бэлэн байдлыг хангууллаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан тус газрын даргын 2017 оны А/03 тоот тушаалаар Ахмадын хотхон-д амьдарч буй харж хандах хүнгүй, ганц бие ахмад настны судалгааг гаргаж, 901 дүгээр байрны 54 тоотод оршин суугч Ц.Дэмбэрэлдорж, 100 тоотын Д.Алтангэрэл, 902 дугаар байрны 17 тоотод оршин суугч Ж.Цэрэндорж, 83 тоотын Д.Цолмон, 96 тоотын Д.Түмэн-Өлзий нарын 5 өндөр настанд хадаг, хэвийн боов, суурь еэвэн, тавгийн чихэр, гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ. Олон улсын ахмад настны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 901,902-р байрны 80 наснаас дээш 35 ахмад настан, байгууллагын 3 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлсэн.

(Зураг-13)



Монгол улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны хаврын бүх нийтээр мод тарих өдрийг 05-р сарын 13-ны өдөр хотхоны байруудын гадна талбайд 10 гацуур, 4 улиас, 1 моносyг суулган хайсаа будаж тохижууллаа.

(зураг -14)



Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах болон бусад нийгэм, соёл, аж ахуйн эрхийг хангуулах чиглэлээр хотхоны цэцгийн мандалуудад цэцгийн суулгац авч орчиныг цэцэгжүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

(зураг -15)




Нийслэлээс зарласан бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд тус газрын бие бүрэлдэхүүн хотхоны 901, 902, 813 дугаар байруудын ойр орчим нийтийн эзэмшлийн 1800м.кв талбайд нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж,



ахуйн болон барилгын хог хаягдалыг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын тусгай зориулалттай хог ачилтын машинаар тээвэрлүүлээ.

(зураг-16)



Тус хотхоны 901,902 дугаар байр, түр суурьшуулах 813 дугаар байрны гадна талбай авто зогсоолын мөстсөн зам талбайг цэвэрлэх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж нийт 850м2 талбайн цас мөсийг цэвэрлэх ажлыг хийж, гудамж зам талбайд цасан бүрхүүл тогтох бүрд ажилчдыг цуглуулж, хотхоны эзэмшлийн ойр орчмын цас мөс цэвэрлэх хуваарь гаргаж, цас хусах багаж 1ш, хүрз 4ш, мөс хагалах царил 4ш, давс 150кг тус тус бэлтгэсэн талаарх мэдээ болон Хотын Ерөнхий менежерийн өгсөн үүрэг даалгаварын дагуу ШУЗТ-ийн 310005 дугаар утсанд мэдээллэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна

“Иргэдийн үгийг сонсож, үр дүнг тайлагнах өдөр” аяны хүрээнд оршин суугч иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авах өдөрлөгийг зохион байгуулж иргэд оршин суугчдаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу орцны гэрэлтүүлгийг шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй амьдралын баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн сантехникийн уян холбоос, 15-ын хаалт, ханын цаас, цонхны зөөлөвч резин, вакум цонхыг шиллэх, цахилгааны монтаж засварлах зэрэг ажлуудыг иргэд оршин суугчдаас гаргасан хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй шинэчлэх ажлыг зохион байгуулж нийт 1 сая гаруй төгрөгийн өртөг бүхий ажлыг дотоод нөөц бололцоогоо ашиглан хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын цахим хуудас [www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn](http://www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn) сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухайд бүр байршуулж, байгууллагын санхүүгийн ил тод байдлыг [www.shilendans.gov.mn/main/agency/10289](http://www.shilendans.gov.mn/main/agency/10289) цахим хуудсыг хөтлөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн, үүрэг даалгаварын биелэлттэй холбоотой мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэж байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 378 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган батлаж, “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ын даргын 2017 оны А/19 дугаартай “Баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” тушаал гарган 2017 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр ХСУСХАҮЗЗ-тэй хамтран хотхоны 901, 902 дугаар байрны иргэд оршин суугчдад Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны “Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай” 94 дүгээр тогтоолыг оршин суугч иргэдэд сурталчилж, үнэ тарифын өөрчлөлтийг нийт 296 айл өрхөд гарын авлага хэвлүүлж хүргүүлэх ажлыг зохион байгуулж оршин суугчдыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Тав. Бусад мэдээлэл

Сүхбаатар дүүрэг 11-р хорооны Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан СӨХ-үүдийн үйл ажиллагаатай танилцсан нэгдсэн хуралд Дулааны инженер Г.Чулуунбаатар оролцож хотхоны байруудын тохижилт, цэвэрлэгээний төлөвлөгөөт ажлуудыг танилцуулав.

“ДШСТӨХК”-иас 2017 оны 3-р сарын 17-ны өдөр зохион байгуулсан орон сууцны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн орон сууцны компани, Сууц өмчлөгчдийн холбооны хариуцсан орон сууцны барилгын дулаанжуулалтын тоноглолуудын ашиглалтын түвшин, өнөөгийн байдал сэдэвт уулзалтанд тус газрын Дулааны инженер Г.Чулуунбаатар, Цахилгааны инженер Э.Жавхлан нар нь оролцож, мэдлэг туршлага хуваалцав.

Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл үр дүнг сайжруулах зорилгоор зохион байгуулагдсан сургалтанд 3 ажилтанг, ДШС ТӨХК-аас 2017 оны 3-р сарын 17-ны өдөр зохион байгуулсан орон сууцны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн орон сууцны компани, Сууц өмчлөгчдийн холбооны хариуцсан орон сууцны барилгын дулаанжуулалтын тоноглолуудын ашиглалтын түвшин, өнөөгийн байдал сэдэвт уулзалт сургалтанд 2 ажилтан, Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн “УХАТ-2017” сэдэвт сертификаттай сургалтанд 2 ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтанд 2 ажилтан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Төрийн албаны зөвлөлтэй хамтран Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар тэдгээрийн биелэлтийг дүгнэх тухай сэдэвт сургалтанд байгууллагын дарга, гэрээний мэргэжилтэн нарыг тус тус оролцуулан мэдлэг боловсролыг дээшлүүлж, ажилчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдүүлж, цаг бүртгэлийн төхөөрөмжийг суурилуулж, ажилчдын цаг

ашиглалтыг сайжруулж, дотоод хяналтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах ажлын хүрээнд тус газрын сантехникч Л.Батзоригийн гэр гал түймэрт өртөж шатсан тул хамт олны хурлын шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад хүсэлт гарган олгосон зөвшөөрлийн дагуу ОНӨААТҮГ газрын захирлын 2017 оны “Туслалцаа үзүүлэх тухай” А/07 дугаар тушаалаар 2,400 мянган төгрөгөөр 5 ханатай гэр худалдан авч ажилтныхаа ар гэрт нь дэмжлэг үзүүлж ажиллаа.

(Зураг-17)



“Цусаа бэлэглэхэд нэгдэх аян”-ы хүрээнд 2017 оны 05 сарын 25-ны өдөр тус байгууллагын ажилтнуудыг бүрэн хамруулж, Сүхбаатар дүүргийн өрхийн эмнэлэгтэй хамтран байгууллагын нийт 18 ажилчдыг 2017 оны 03-р сарын 13-нд анхан шатны үзлэгт оруулж, 2 дахь шатны нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР